



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2025 оны 08 дугаар сарын 12
№32 (1377)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

188.	Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай	1506
189.	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай	1507
190.	Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1508
191.	Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай	1513
192.	Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1514
193.	Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай	1516
194.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1517
195.	Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1518
196.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1520
197.	Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1523
198.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1526
199.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	1528



200.	Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		1533
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ			
201.	Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар дүгнэлтийн тухай	Дугаар 66	1535
202.	Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай	Дугаар 75	1537
203.	Байнгын хорооны даргыг улируулан сонгох тухай	Дугаар 76	1539
204.	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 77	1540
205.	Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 79	1554
206.	Байнгын хорооны даргыг улируулан сонгох тухай	Дугаар 81	1557
207.	Зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай	Дугаар 82	1558
208.	“Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 85	1559
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ			
209.	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 06	1563

[illegible]

Улаанбаатар
ХОТ

ХАРЬЯТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Харьяатын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “мэргэшил эзэмшсэн,” гэсний дараа “олимпын наадмын хөтөлбөрт багтах спортын төрөлд, эсхүл” гэж нэмсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.АМАРБАЯСГАЛАН

[illegible]

සුද්ධ සංගමය

٦ قصص مصداق... مستحق لكل حسن يحسنه له في قصص مصداق
من الحكمة من «القصص العبرية»... ليس في صحتها «المصداق»
نفسهم من القصص التي تستحقها من المصداق... . المصداق»...
نفسهم..

2010-2011

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
ХОТ

**АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ
ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсгийн “21.3.1,” гэсний дараа “21.3.7,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.АМАРБАЯСГАЛАН

[illegible]

የጋራ ጥቅም ላይ የሚውል ሲሆን

[illegible][illegible]

۴۰. $\frac{1}{2} \times \frac{1}{3} = \frac{1}{6}$



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ, ГЭР ХОРООЛЛЫГ ОРОН СУУЦЖУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, заалт нэмсүгэй:

1/7¹ дүгээр зүйл:

“7¹ дүгээр зүйл. Газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сан

7¹.1. Нийслэл хотын газрыг дахин төлөвлөх, гэр хорооллыг орон сууцжуулах, агаар, хөрсний бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлтийг дэмжих, орон сууцны санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх зориулалттай Газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сантай байна.

7¹.2. Газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сангийн хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

7¹.2.1. орон нутгийн төсөв;

7¹.2.2. гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд бий болсон орон сууцыг худалдан борлуулснаас олсон орлого;

7¹.2.3. газрыг дахин төлөвлөх хүрээнд газрыг дуудлага худалдаагаар худалдан борлуулсан орлого;

7¹.2.4. хуулиар хориглоогүй хандив, тусламж, бусад.

7¹.3. Газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сангийн хөрөнгийг доор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

7¹.3.1. инженерийн болон нийгмийн дэд бүтцийг бий болгох, гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртсөн иргэн, хуулийн этгээдийн нөхөх олговрын зардал;

7¹.3.2. айл, өрхийн гэрийн дулаалга, дулаан алдагдлыг бууруулах төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх;

7¹.3.3.ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулгах, шинээр барих;

7¹.3.4.орон сууцны бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүүгийн зөрүүг төлөх.

7¹.4.Газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журмыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, түүний хэрэгжилтэд хяналт тавина.

7¹.5.Газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сангийн дүрмийг нийслэлийн Засаг дарга батална.

7¹.6.Газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сангийн тайлан, зарцуулалт ил тод, нээлттэй байна.”

2/18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалт:

“18.1.8.мэдээллийн систем, хиймэл оюун ашиглаж замын хөдөлгөөний урсгалыг оновчтой зохион байгуулах, түгжрэлийг бууруулах, аюулгүй байдлыг хангах, зөрчил илрүүлэх, ослын хяналтыг сайжруулах;”

3/19 дүгээр зүйлийн 19.2.5 дахь заалт:

“19.2.5.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчлийг илрүүлэх, шийдвэрлэх автоматжуулсан системийг хариуцан ажиллах;”

2 дугаар зүйл.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “автобусны” гэснийг “автобус, таксины” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “үйл ажиллагааг” гэснийг “үйл ажиллагааг Газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сан болон” гэж, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “зарцуулна.” гэснийг “болон Газрыг дахин төлөвлөх, гэр хорооллын хөгжлийн сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор борлуулна.” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалтын дугаарыг “18.1.9” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2.5 дахь заалтын дугаарыг “19.2.6” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийн 7¹ дүгээр зүйлийн 7¹.2.1 дэх заалтыг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.АМАРБАЯСГАЛАН

عصمہ م عسفی

الحمد لله

٢٠٥٦ هـ و ١٣٧٤ م - ١٩٥٣ م

[illegible]

٦/٤٠ قصص اعدا :

«فَصَلِّ لِحَقِّكَ خَمْسًا مِائَةً مَرَّةً»

[illegible][illegible]

:
 ۱- در این فصل، به بررسی و مقایسهٔ روش‌های مختلف برای حل مسائل بهینه‌سازی می‌پردازیم.
 ۲- در فصل دوم، به معرفی و تحلیل روش‌های عددی برای حل معادلات دیفرانسیل خواهیم پرداخت.
 ۳- در فصل سوم، به بررسی و مقایسهٔ روش‌های مختلف برای حل مسائل بهینه‌سازی می‌پردازیم.

[illegible]

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
ХОТ

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсгийн “үнэт цаас,” гэсний дараа “нийслэлийн үнэт цаас,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.АМАРБАЯСГАЛАН

بعضیوں نے بعض مریضوں کو ۱۵-۲۰ گرام فی ۲۴ گھنٹہ کی مقدار میں دیا ہے۔

اسماء الحسنیٰ

[illegible][illegible][illegible]



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 8.2.4 дэх заалт нэмсүгэй:

“8.2.4. агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өрхийг хийн түлшээр хангах, урамшуулал олгох журам батлах;”

2 дугаар зүйл. Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.4 дэх заалтын дугаарыг “8.2.5” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3 дахь заалтын “амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

مجلس علماء العرب والمسلمين

የግል ጥቅም

٢٠٢٥ م و ٢٠٢٦ م حصص من الحصة - و حصص

استن م حسن حسين كو نسيف
احمد حسين احمد حسين حسن

٦ فصل في تصنيف النسيج :-

[illegible]

۶. فصلنامه علمی-پژوهشی «مطالعات فرهنگی»

[illegible][illegible]

المطبخ العربي

Dr. Indira Anand



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Автотээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17.6 дахь хэсэг нэмсүгэй:

“17.6.Энэ хуулийн 17.1-д заасан автотээврийн хэрэгслийн техникийн хяналтыг Нийслэлийн Засаг даргад шилжүүлж болно.”

2 дугаар зүйл.Автотээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“17.3.Энэ хуулийн 17.6-д заасны дагуу эрх шилжүүлснээс бусад автотээврийн хэрэгслийн техникийн үйл ажиллагааг эрхлэн явуулах байгууллага нь автотээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд ажиллана.”

3 дугаар зүйл.Автотээврийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3 дахь хэсгийг, 17¹ дүгээр зүйлийн 17¹.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

Хүснэгт 1. Хүснэгт 1

Хүснэгт 1. Хүснэгт 1

Хүснэгт 1. Хүснэгт 1

Хүснэгт 1. Хүснэгт 1

Хүснэгт 1. Хүснэгт 1

Хүснэгт 1. Хүснэгт 1

Хүснэгт 1. Хүснэгт 1

Хүснэгт 1. Хүснэгт 1

Хүснэгт 1. Хүснэгт 1

Хүснэгт 1. Хүснэгт 1

Хүснэгт 1. Хүснэгт 1

Хүснэгт 1. Хүснэгт 1



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/9 дүгээр зүйлийн 9.4.8 дахь заалт:

“9.4.8.нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагатай хамтран энэ хуулийн 9.2.4-т заасан шийдвэрийн биелэлтийг хэрэгжүүлэх.”

2/21 дүгээр зүйлийн 21.6 дахь хэсэг:

“21.6.Баруун гар талдаа жолооны хүрдтэй механикжсан тээврийн хэрэгслийг Монгол Улсын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөнд оролцуулах зорилгоор импортлохыг хориглоно.”

2 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“14.6.Сургалт явуулах стандартын шаардлагагыг хангаагүй, эсхүл сургалтыг хангалтгүй зохион байгуулсан нь жолооч бэлтгэх сургалтын байгууллагын үйл ажиллагааг зогсоох үндэслэл болно.”

3 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн “журмыг” гэснийг “болон шалгалтын хураамжийн хэмжээ, түүнийг зарцуулах журмыг” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.4 дэх заалтын “, зөрчлийн бүртгэлийн оноо тооцох” гэснийг, мөн зүйлийн 8.3 дахь хэсгийн “зөрчлийн бүртгэлийн оноо тооцох” гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3 дахь заалтыг, 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг, 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалтыг, мөн зүйлийн 18.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Жолоочийн даатгалын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэг:

“13.7. Даатгуулагч энэ хуулийн 16.6-д заасан тохиолдолд энэ хуулийн 13.1.2-т заасан цагдаагийн байгууллагад мэдэгдэх үүргээс чөлөөлөгдөнө.”

2/16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсэг:

“16.7. Энэ хуулийн 16.6-д заасан тохиолдолд даатгагч энэ хуулийн 15.2-т заасан үүргээс чөлөөлөгдөх ба хохирогчийн эд хөрөнгөд учирсан хохирлыг барагдуулахдаа үнэлгээний тайлан шаардахгүйгээр эд хөрөнгийг засуулахаар тохиролцож болно.”

2 дугаар зүйл. Жолоочийн даатгалын тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг:

“13.3. Энэ хуулийн 13.1, 13.2-т заасан этгээд нь даатгалын тохиолдлын тодорхойлолтын маягтыг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр даатгалын тохиолдол гарсан даруйд бөглөнө.”

2/16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсэг:

“16.6. Даатгалын тохиолдлын улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохироогүй, холбогдогч талуудын тээврийн хэрэгслээс бусад эд хөрөнгийн хохиролгүй, холбогдогч талууд өөр хоорондоо маргаангүй тохиолдолд даатгагч, жолоочийн даатгалын сан нь даатгалын тохиолдлын талаарх мэдээлэл, баримтыг цахимаар даатгуулагч болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.6-д заасан автоматжуулсан системээс хүлээн авч, нөхөн төлбөрийг шийдвэрлэнэ.”



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 58 дахь хэсэг нэмсүгэй:

“58.Замын хөдөлгөөний дүрэмд зааснаар уулзвар нэвтрэх журам зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 3.4 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн “хуульд заасан хугацаанд биелүүлээгүй” гэсний дараа “, эсхүл авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй” гэж, 3.5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “14.6” гэсний дараа “14.7 дугаар зүйлийн 1, 5, 18, 51 дэх хэсэг” гэж, 14.7 дугаар зүйлийн 18 дахь хэсгийн “хүлээлгэхээргүй бол” гэсний дараа “тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 11.15 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.Жолооч нь жолоочийн даатгалд даатгуулалгүйгээр тээврийн хэрэгслээ ашиглан замын хөдөлгөөнд оролцсон бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

کتابخانه عمومی

الحمد لله رب العالمين

٢٠٢٢م و ٢٠٢٣م فصلين مهين ٢ الحام ٥٥-٥٦ و الحاصن

محکمہ صحت و صحت کے امور
محکمہ صحت و صحت کے امور

[illegible]

«لَمْ يَمُوتْ» هُوَ الْمُسْتَعْمَلُ فِي الْمَقَامِ الْمَذْكُورِ لِأَنَّ الْمُسْتَعْمَلَيْنِ الْآخَرَيْنِ لَا يَنْبَغِي أَنْ يَكُنَّ مُتَعَدِّدَتَيْنِ فِي الْمَقَامِ الْمَذْكُورِ

[illegible][illegible][illegible][illegible]

የግንባታው ስራ

Dr. Michael A. Smith



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/1.4 дүгээр зүйлийн 1.6 дахь заалт:

“1.6.“замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчлийг илрүүлэх, шийдвэрлэх автоматжуулсан систем” /цаашид “автоматжуулсан систем” гэх/ гэж замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийг өнгө, улсын дугаар, төрөл, үйлдвэрлэгчээр нь таньж, жолоочийн үйлдлийг замын хөдөлгөөний дүрмийн заалттай тулган шалгах, зөрчлийг илрүүлэх, шийдвэрлэх ажиллагааг автоматжуулсан мэдээллийн системийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, программ хангамж, тэдгээрийг ажиллуулах хүний нөөц, санхүүгийн үүсвэрийн харилцан уялдаа бүхий цогцыг.”

2/1.8 дугаар зүйлийн 6.66 дахь заалт:

“6.66.Хотын стандартын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.30 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт заасан зөрчил.”

3/2.2 дугаар зүйлийн 8, 9 дэх хэсэг:

“8.Зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, харилцан мэдээлэл солилцох зорилго бүхий зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай байна.

9.Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл нийлүүлэх, солилцох, ашиглах, мэдээлэлтэй танилцах журмыг энэ хуульд нийцүүлэн Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”

2 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “зөрчил илрүүлсэн бол” гэсний дараа “, эсхүл дагнасан чиг үүрэгтэй алба, нэгжид” гэж, 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “6.30” гэсний дараа “, 6.32, 6.62, 6.63” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “6.61” гэсний дараа “, 6.64, 6.65, 6.66” гэж, 7.2 дугаар зүйлийн

1 дэх хэсэгт “Шийтгэлийн хуудас нь цахим хэлбэртэй байж болно.” гэсэн 2 дахь өгүүлбэр, 7.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “мэдээлэх” гэсний дараа “, тээврийн хэрэгслийг саатуулах, тусгай талбайд хүргэх” гэж, 7.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “6.30” гэсний дараа “6.32,” гэж, “6.62” гэсний дараа “, 6.63” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “6.31,” гэсний дараа “6.33,” гэж, “6.61” гэсний дараа “, 6.63, 6.64, 6.65, 6.66” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1.Зөрчил үйлдэгдсэн нь ил тодорхой, эсхүл стандартаар баталгаажсан хэмжилт-хяналтын төхөөрөмжөөр нотлогдсон, зөрчил, учирсан хохирлыг нотлох талаар зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах шаардлагагүй бол эрх бүхий албан тушаалтан зөрчлийг газар дээр нь шийдвэрлэнэ. Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн 10.2, 10.3 дахь заалт, 11, 16, 17, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29 дэх хэсгийн 29.1, 29.3 дахь заалт, 31, 34, 35, 36, 37, 38, 39, 40, 41, 42, 44, 45, 46, 47, 48, 50, 57, 58 дахь хэсэгт заасан зөрчлийг илрүүлэх, шийдвэрлэх ажиллагааг автоматжуулсан системээр гүйцэтгэсэн бол шийтгэлийн хуудсыг эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсгээр баталгаажуулж болно.

2.Зөрчил үйлдэгдсэн нь тодорхой, холбогдогч зөрчил үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрсөн боловч учруулсан хохирлыг нотлох баримтаар тогтоох шаардлагатай бол эрх бүхий албан тушаалтан зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэнэ.”

4дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.6 дахь заалтын “6.30 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг,” гэснийг “6.30 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг,” гэж, “53 дахь хэсэгт” гэснийг “53, 57 дахь хэсэгт” гэж, 2.3 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын “прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх,” гэснийг “зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэх,” гэж, 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “прокурорын нэгдсэн бүртгэлд” гэснийг “зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд” гэж, 6.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 6.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 6.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ.” гэснийг “зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ.” гэж, 6.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “прокурорын нэгдсэн бүртгэлд даруй бүртгүүлнэ.” гэснийг “зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд даруй бүртгэнэ.” гэж, 6.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “прокурорын нэгдсэн бүртгэлд даруй бүртгүүлж,” гэснийг “зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд даруй бүртгэж,” гэж, 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт” гэснийг “6.6 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт” гэж, 7.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “3.8 дугаар зүйлийн” гэснийг “3.10 дугаар зүйлийн” гэж, 7.5

«...»

[illegible]

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/22 дугаар зүйлийн 22.1.15 дахь заалт:

“22.1.15.нийслэл Улаанбаатар хот, түүний дагуул хотод мөрдөх хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;”

2/22 дугаар зүйлийн 22.7 дахь хэсэг:

“22.7.Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хяналт шалгалтын асуудал хариуцсан захиргааны байгууллага энэ хуулийн 22.1.15-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий улсын байцаагчтай байна.”

2 дугаар зүйл.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.15 дахь заалтын дугаарыг “22.1.16” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.АМАРБАЯСГАЛАН

ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА

ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА

2025 он 05 сарын 05 - өдөр

ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА
ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА
ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА

6. ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА
ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА
ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА

7. ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА

8. ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА
ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА
ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА

9. ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА

10. ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА
ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА
ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА

11. ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА
ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА
ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА

12. ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА
ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА
ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА

ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА
ҮЙЛДЭГЧИЙН ХАМГАА

МОНГОЛ УЛСЫН ХАМГАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 07 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 66

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “..., хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг, Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.” гэж заасныг, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “..., үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, ..., өмчлөх, ... эрхтэй. ...” гэснийг тус тус зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 06 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.АМАРБАЯСГАЛАН

Булгагч: Хүснэгт 1-ийн 1-д үзүүлсэн

Бүтээгдэхүүний нийт

Хүснэгт 1-ийн 1-д

Хүснэгт 1-ийн 1-д 1-д 1-д

Бүтээгдэхүүний нийт
Хүснэгт 1-ийн 1-д 1-д 1-д

Бүтээгдэхүүний нийт
Хүснэгт 1-ийн 1-д 1-д 1-д

Бүтээгдэхүүний нийт
Хүснэгт 1-ийн 1-д 1-д 1-д

Бүтээгдэхүүний нийт
Хүснэгт 1-ийн 1-д 1-д 1-д

Бүтээгдэхүүний нийт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 07 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар
хот

Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны даргаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягийг сонгосугай.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэнг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.АМАРБАЯСГАЛАН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 07 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 76

Улаанбаатар
хот

Байнгын хорооны даргыг улируулан сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатарыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны даргаар улируулан сонгосугай.

2.Энэ тогтоолыг 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠡ ᠬᠣᠷᠣᠨ ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠠᠨ
ᠲᠤᠭᠠᠭ 76
ᠲᠤᠭᠠᠭ ᠒᠕-ᠨᠠ ᠶᠡᠳᠡᠷ

ᠪᠠᠶᠢᠩᠭᠠᠨ ᠬᠣᠷᠤᠨ ᠳᠠᠷᠭᠢᠭ ᠤᠯᠢᠷᠠᠭᠠᠨ
ᠰᠣᠩᠭᠠᠬᠤ ᠲᠤᠬᠠᠢ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠣᠷᠣᠨ ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠡᠭᠡᠯᠡᠭ-ᠤᠨ 25 ᠳᠤᠭᠠᠭ ᠵᠡᠭᠡᠯᠡᠭ-ᠤᠨ 25.6,
25.7 ᠳᠠᠬᠤ ᠬᠡᠰᠡᠭ, ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠣᠷᠣᠨ ᠴᠡᠭᠣᠯᠭᠠᠨ ᠬᠣᠷᠠᠯᠳᠠᠭ-ᠤᠨ ᠳᠡᠭᠡᠨ
ᠲᠤᠬᠠᠢ ᠬᠡᠭᠡᠯᠡᠭ-ᠤᠨ 23 ᠳᠤᠭᠠᠭ ᠵᠡᠭᠡᠯᠡᠭ-ᠤᠨ 23.1, 23.2 ᠳᠠᠬᠤ ᠬᠡᠰᠡᠭ, ᠰᠠᠨᠠᠯ ᠬᠣᠷᠠᠭᠠᠯᠲᠤᠨ
ᠳᠦᠩᠭ ᠦᠨᠳᠡᠰᠣᠯᠡᠨ ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠣᠷᠠᠭ ᠲᠣᠭᠲᠣᠭ ᠨᠢ:

1.ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠣᠷᠣᠨ ᠭᠢᠰᠢᠭᠦᠨ ᠳᠠᠮᠳᠢᠨᠠ ᠴᠣᠭᠲᠤᠭᠠᠲᠠᠷᠢᠭ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ ᠶᠡᠬᠣᠷᠣᠨ ᠬᠡᠭᠡᠯᠡᠭ ᠵᠡᠭᠡᠨ ᠪᠠᠶᠢᠩᠭᠠᠨ ᠬᠣᠷᠤᠨ ᠳᠠᠷᠭᠠᠭ ᠤᠯᠢᠷᠠᠭᠠᠨ
ᠰᠣᠩᠭᠠᠭᠠᠢ.

2.ᠡᠨᠡ ᠲᠣᠭᠲᠣᠭᠣᠯᠢᠭ 2025 ᠤᠨ 07 ᠳᠤᠭᠠᠭ ᠰᠠᠷ-ᠤᠨ 08-ᠨᠠ ᠶᠡᠳᠡᠷᠡᠭ ᠬᠡᠯᠡᠨ
ᠳᠠᠭᠠᠭ ᠮᠥᠷᠳᠦᠭᠡᠢ.

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ-ᠤᠨ
ᠶᠡᠬᠣᠷᠣᠨ ᠳᠠᠷᠭᠠ

ᠳ.ᠠᠮᠠᠷᠪᠠᠶᠠᠰᠭᠠᠯᠠᠨ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 07 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 77

Улаанбаатар
хот

Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 24 дэх илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2024 оны тайланг хэлэлцээд хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, дэмжих чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/, Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо /П.Дэлгэрнаран/-нд тус тус даалгасугай:

1/Сонгох, сонгогдох эрхийн талаар:

а/сонгуулийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, уг үнэлгээний тайланд үндэслэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар санал боловсруулах;

б/хөгжлийн бэрхшээлтэй иргэн, гадаад улсад байгаа болон Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа боловч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн хаягнаас өөр газарт байгаа иргэн, оюутан, суралцагчид, сонгуулийн санал авах өдөр албан үүргээ гүйцэтгэж байгаа төрийн албан хаагч, уртын ээлжээр ажиллаж байгаа ажилтан зэрэг сонгогчдын сонгох эрхийг эдлүүлэх, санал өгөх боломжит хувилбарыг тодорхойлж, эрх зүйн зохицуулалтыг бий болгох талаар санал боловсруулах;

в/сонгогчдын боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр, арга хэмжээг зөвхөн сонгуулийн жилээр хязгаарлахгүйгээр тогтмол хэрэгжүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах, сонгуулийн үйл ажиллагаатай холбогдох тухайлсан асуудал бүрээр статистик мэдээллийн санг бүрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

г/эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан, залуучууд зэрэг нийгмийн олон талт бүлгийн төлөөллийг

сонгуульд нэр дэвшихэд нь дэмжих, тэдгээрийн сонгогдох эрхийг эдлүүлэхэд чиглэсэн түр тусгай арга хэмжээ авах талаар судалж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар санал боловсруулах;

д/сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, стандартыг сахиулах, гомдол, маргааныг үр дүнтэй шийдвэрлэх, үр нөлөөтэй хариуцлага тооцох, зөрчигдсөн эрхийг бодитой сэргээх тогтолцоог бүрдүүлэх талаар санал боловсруулах.

2/Хүний эрх хамгаалагчийг хамгаалах талаар:

а/өмгөөлөгчийг хуульд заасан өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлсэнтэй нь холбогдуулан эрүүгийн болон зөрчлийн хэрэгт холбогдуулан хууль бусаар шалгах, халдашгүй чөлөөтэй байх эрхийг хязгаарлах, хариуцлага хүлээлгэхгүй байх баталгаагаар хангах;

б/өмгөөлөгчийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлсэнтэй нь холбогдуулан айлган сүрдүүлэх, хүчирхийлэх, дарамт, шахалт үзүүлэх, бусад байдлаар нөлөөлсөн этгээдийн үйлдлийг үр дүнтэй мөрдөн шалгах, хариуцлага хүлээлгэх тогтолцоог боловсронгуй болгох;

в/өмгөөлөгч цахим шүүх хуралдааны үед үйлчлүүлэгч болон бусад оролцогчтой чөлөөтэй харьцах, ямар ч үед үйлчлүүлэгчтэйгээ ганцаарчлан уулзах, түүний байгаа газарт чөлөөтэй нэвтрэх эрхийг хязгаарласан байгууллагын дотоод дүрэм, журмыг хуульд нийцүүлэх.

3/Хүний эрх ба цахим технологийн талаар:

а/цахим технологийн хүний эрхийн нөлөөллийг тооцох аргачлалыг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулах, уг аргачлалаар төрийн үйлчилгээ, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн, эсхүл нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа цахим технологид үнэлгээ хийх зохицуулалтыг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд тусгах;

б/Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар тодорхойлсон мэдээллийн эзний эрхийг хамгаалах, хууль тогтоомжид заасныг зөрчсөн мэдээлэл хариуцагч болон мэдээлэл боловсруулагчийн үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг, зөрчилд тооцох, хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх асуудлыг судлах;

в/Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн биелэлтийг хангах, мэдээлэл хамгаалах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх талаар үе шаттайгаар хэрэгжүүлэх бодлогыг тодорхойлох;



г/нийтийн болон хувийн орон зайд байрших дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн систем, хүнийг тагнах, мөрдөн мөшгих боломжтой бүх төрлийн цахим төхөөрөмжөөс хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх чөлөө, хүний хувийн мэдээллийг хамгаалах зохицуулалтыг холбогдох хуульд нарийвчлан тусгах;

д/хиймэл оюуны хөгжүүлэлт, ашиглалттай холбоотойгоор хүн төвтэй байх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, мэдээлэл, өгөгдлийн боловсруулалт ил тод байх, хариуцлагатай байх гэсэн зарчмуудыг уг илтгэлд тайлбарласан агуулгаар “Үндэсний хиймэл оюуны стратеги”-д тусгаж, улмаар Монгол Улсад хөгжүүлэх, ашиглахыг хориглох хиймэл оюуны төрлийг тодорхойлох;

е/хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангах болон худал мэдээлэл, хүчирхийлэл, үзэн ядалтыг сэдэлжүүлэх илэрхийлэл бүхий гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй контентын зохист тэнцвэрийг хэрхэн хангахтай холбоотой бодлогыг тодорхойлох;

ё/ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, алслагдсан орон нутгийн болон орлого багатай өрх, монгол хэлээр харилцах боломжгүй хүмүүсийн цахим технологийн хүртээмжийг нэмэгдүүлэх, тэдгээрийн ялгаатай байдлыг харгалзан хэрэгцээнд нь нийцүүлэн хэрэглээний үр чадвар олгох сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн боловсруулах, үр дүнтэй сургах, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний шинжлэх ухааны дэвшлийн үр шимийг хүртэх эрхийг хангах асуудлыг тусгасан цахим хуваагдлыг арилгах бодлогыг тодорхойлж, батлах, хэрэгжүүлэх;

ж/корона вируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үеэр цуглуулсан хүний хувийн мэдээлэл, түүний ашиглалт, үйл ажиллагааг Засгийн газрын дотоод хяналтын хүрээнд шалгах.

4/Цахим орчинд үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллээс хамгаалах талаар:

а/цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчийн онцлог байдал, үйлдлийн арга, хэлбэр, цаашид бий болох хор уршиг, хохирлын талаар нарийвчлан судалж, энэ төрлийн хүчирхийлэлтэй үр дүнтэй тэмцэхэд шаардлагатай зохицуулалтыг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон холбогдох бусад хуульд тусгах боломжийг судлах;

б/Эрүүгийн хуулийн 10.4, 11.7, 13.1, 13.5, 13.12, 14.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдалд цахим технологи ашиглан үйлдсэн арга, хэлбэрийг тусгах;

в/цахим технологи ашиглан цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийг мөрдөн шалгах, цахим нотлох баримтыг илрүүлэх, бэхжүүлэх, үнэлэх аргачлал боловсруулж, кибер халдлагатай тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчдад зориулсан сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах, хүний нөөцийн болон санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх, бэхжүүлэх, энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх;

г/цахим технологи ашиглан үйлдэгдэж буй жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилсан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хүүхэд, эмэгтэйчүүд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан мэдээллийг тэдгээрийн онцлог байдал, хэрэгцээнд нийцүүлэн ойлгогдохуйц, хүртээмжтэй хэлбэрээр бэлтгэж хүргэх, нөлөөллийн үйл ажиллагааг төлөвлөж, бүх талуудын оролцоотойгоор хэрэгжүүлэх.

5/Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийг хамгаалах талаар:

а/насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн статистик мэдээллийг нарийвчлан гаргаж, энэ төрлийн гэмт хэргийн криминологийн цогц судалгааг хийх, уг судалгааны үр дүнд үндэслэн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах, урьдчилан сэргийлэх арга хэлбэрийг шинэчлэх;

б/насанд хүрээгүй хохирогчтой ярилцлага хийх, тайлбар, мэдүүлэг авах ажиллагааг цагдаагийн байгууллагын байрнаас өөр газарт буюу хүүхдийн насны онцлогт тохирсон, хүүхдэд аюулгүй, ээлтэй, хүртээмжтэй орчинд мэргэшсэн сэтгэл зүйч, эсхүл нийгмийн ажилтантай ярилцлага хийх хэлбэрээр нэг удаа, шуурхай явуулах бөгөөд дуу, дуу-дүрсний бичлэгээр баримтжуулж нотлох баримтад тооцдог байх, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд насанд хүрээгүй хохирогч заавал өмгөөлөгчтэй оролцдог байх асуудлаар холбогдох эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

в/бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн эрхийг хамгаалах, дахин хохирохоос урьдчилан сэргийлэх тусгай журмыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгах;

г/хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүүхдийн эрхийг хамгаалах үүрэгтэй хүүхэд хамгааллын тогтолцооны хамтарсан баг, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхдийн эрхийн улсын байцаагч, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын бодит оролцоог хангаж, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;



д/насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох шинжээч, хууль ёсны төлөөлөгчөөр томилогдох хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын ажилтан, өмгөөлөгч, мөрдөгч, прокурор, шүүгчийг тусгайлан мэргэшүүлэн бэлтгэх чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, энэ төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зөвхөн мэргэшиж бэлтгэгдсэн оролцогчийг оролцуулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

е/Гэр бүл, хүүхдийн хэргийн шүүх байгуулагдаж байгаатай холбоотойгоор мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, салбар дундын уялдаа холбоог хангах, бэлтгэл ажлыг эрчимжүүлэх чиглэлээр эрхлэх асуудлын хүрээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

6/Шударгаар шүүлгэх эрхийн хэрэгжилтийн талаар:

а/эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад сэтгэцийн шинжилгээ хийх, нэгжлэг хийх, эд хөрөнгө битүүмжлэх зэрэг хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хязгаарлах ажиллагааны зөвшөөрлийг прокурорын саналыг үндэслэн шүүх шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

б/хэрэг хариуцах чадвартай боловч сэтгэцийн эмгэгтэй хүнд шинжилгээ хийх, оношлох чадавхыг бэхжүүлэх, тэдгээр хүмүүст ял оногдуулахын зэрэгцээ албадан эмчилгээ хийх, суллагдсаны дараа хяналт тавих эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг авах;

в/эрүүгийн болон зөрчлийн хэргийг аль болох богино хугацаанд шийдвэрлэх чадавхыг бэхжүүлэх, хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын ажлын ачааллыг үндэслэлтэйгээр тооцож, шийдвэрлэх талаар эрх зүй, зохион байгуулалтын цогц арга хэмжээг авах;

г/эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд ашиглах цахим системийг нэвтрүүлэх, хөгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

д/гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнд олж авсан нотлох баримтыг шүүхийн шатанд ил болгож хавтаст хэрэгт тусгах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

е/баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргасан даруйд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

ё/гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төр эхлэн барагдуулах, түүнчлэн хохирлыг нөхөн төлөх төсвийн эх үүсвэрийг гэм буруутай этгээдээс гаргуулсан мөнгөн төлбөр, гэмт хэрэг, зөрчлийн торгууль, хүүгийн орлого, авлигын улмаас хураагдсан хөрөнгө орлого зэргээс бүрдүүлэх зохицуулалт бүхий Гэмт хэргийн хохирлыг нөхөн төлүүлэх сангийн тухайлсан хуультай болох эсэх асуудлаар хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалж, шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төслийг боловсруулах;

ж/эрүү шүүлтийн хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн хууль зүйн, эрүүл мэнд, нийгмийн болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, нийгмийн харилцаанд эргэн ороход дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах тухайлсан хуультай болох эсэх асуудлаар хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалж, шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулах;

з/хууль сахиулагч бэлтгэх сургалтын тогтолцоо, хөтөлбөрийн агуулгад дүн шинжилгээ хийх, хүний эрхийн стандартад нийцүүлэн хөгжүүлэх, хэрэгжүүлэх арга хэмжээг авах;

и/хорих анги, цагдан хорих байр, цэргийн анги, хүний эрх чөлөөг хязгаарлах чиг үүрэгтэй газар болон хууль сахиулагчийн ажлын байранд хүний сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.

7/Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудлаар:

а/эрүүдэн шүүхээс бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар болон хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйлдлийг гэмт хэрэгт тооцох асуудлыг судалж, шаардлагатай гэж үзвэл хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах;

б/Эрүүгийн хуулийн 10, 11, 21 дүгээр бүлэгт зохицуулсан “эрүүдэн шүүх” үйлдлийг нэгтгэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар судлах;

в/эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдолд эрүү шүүлт тулгах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийн хөөн хэлэлцэх хугацаа дууссаныг хамааруулахгүй байх;

г/Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэн үндэсний хэмжээнд хүний эрхийн сургалтын нэгдсэн хөтөлбөрийг Станбулын протоколд нийцүүлэн боловсруулах;



д/эрүү шүүлт тулгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэргийг хараат бусаар хянан шалгах бие даасан бүтэц байгуулах.

2.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын болон гишүүний зөвлөмж, шаардлагыг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих, хэрэгжүүлээгүй төрийн байгууллага, албан тушаалтанд хариуцлага тооцох саналаа боловсруулж Улсын Их Хуралд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс /Д.Сүнжид/-т тус тус даалгасугай.

3.Энэ тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/, Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо /П.Дэлгэрнаран/-нд тус тус даалгасугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо /Д.Цогтбаатар/, Төрийн байгуулалтын байнгын хороо /Ц.Сандаг-Очир/-нд тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.АМАРБАЯСГАЛАН

Борлуулж байгаа үр дүнг үнэлж үзэх

Мэдээллийн үйлчилгээ

Хүснэгт 2

2025 оны 2-р сарын 1-н хүртэл

Борлуулж байгаа үр дүнг үнэлж үзэх
2-р сарын 1-н хүртэл
Мэдээллийн үйлчилгээ
2025 оны 2-р сарын 1-н хүртэл

Борлуулж байгаа үр дүнг үнэлж үзэх
2-р сарын 1-н хүртэл
Мэдээллийн үйлчилгээ
2025 оны 2-р сарын 1-н хүртэл

Борлуулж байгаа үр дүнг үнэлж үзэх
2-р сарын 1-н хүртэл
Мэдээллийн үйлчилгээ
2025 оны 2-р сарын 1-н хүртэл

Борлуулж байгаа үр дүнг үнэлж үзэх
2-р сарын 1-н хүртэл

Борлуулж байгаа үр дүнг үнэлж үзэх
2-р сарын 1-н хүртэл
Мэдээллийн үйлчилгээ
2025 оны 2-р сарын 1-н хүртэл

Борлуулж байгаа үр дүнг үнэлж үзэх
2-р сарын 1-н хүртэл
Мэдээллийн үйлчилгээ
2025 оны 2-р сарын 1-н хүртэл

Борлуулж байгаа үр дүнг үнэлж үзэх
2-р сарын 1-н хүртэл
Мэдээллийн үйлчилгээ
2025 оны 2-р сарын 1-н хүртэл

[illegible][illegible][illegible][illegible][illegible][illegible][illegible]

Dr. Mervyn Matthews



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 07 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар 79

Улаанбаатар
хот

Зээлийн хүүг бууруулах хүрээнд авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 22.3.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Зээлийн хүүг бууруулах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монголбанк /Б.Лхагвасүрэн/-нд даалгасугай:

1/банкны системийн тухайн хугацааны дундаж хүүгээс өндөр хүүтэй татсан хугацаатай хадгаламж нь банкуудын эх үүсвэрийн өртөг, зээлийн хүүг тогтооход хэрхэн нөлөөлж байгаа талаар судалгаа хийж, саналаа танилцуулах;

2/банкнаас эрсдэл багатай зээлдэгчид олгох зээлийн хүүгийн мэдээллийг ил тод, нээлттэй зарладаг болох зохицуулалтыг холбогдох журамд тусгах;

3/Монгол Улсад гадаадын банк үйл ажиллагаа эрхлэх харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хүрээнд гадаадын банкны салбар байгуулах, үйл ажиллагаа эрхлэх нөхцөл, шалгуурыг шинэчлэх, боловсронгуй болгох.

2.Зээлийн хүүг бууруулж, банкнаас бусад санхүүгийн салбарыг хөгжүүлэх хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Санхүүгийн зохицуулах хороо /Т.Жамбаажамц/-нд даалгасугай:

1/банк болон банк бус санхүүгийн байгууллага хөрөнгийн зах зээлээр дамжуулан эх үүсвэр татахад дэд бүтцийн байгууллагатай холбогдох зардал, хугацааг бууруулах;

2/банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг тогтоохтой холбоотой шаардлага, шалгуурыг төв болон орон нутгийн нөхцөл байдалд нийцүүлэн ялгамжтай тогтоох.

3.Зээлийн хүүгийн дээд хязгаарыг бизнесийн, хэрэглээний болон бусад зээлийн бүтээгдэхүүн тус бүрээр төрөлжүүлэн судалж, санал боловсруулан танилцуулахыг Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн

зохицуулах хороо /Т.Жамбаажамц/-нд, банк, эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээг үл хөдлөх эд хөрөнгийн барьцаанд тулгуурлан тооцох журмыг зээлжих чадварын зэрэглэлтэй уялдуулан боловсронгуй болгох чиглэлээр санал боловсруулж, танилцуулахыг, энэ тогтоолын биелэлтийн явцыг 2025 оны 12 дугаар сард багтаан Монгол Улсын Их Хуралд танилцуулахыг Монголбанк /Б.Лхагвасүрэн/, Санхүүгийн зохицуулах хороо /Т.Жамбаажамц/, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн /Б.Жавхлан/-нд тус тус даалгасугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Р.Сэддорж/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 82

Улаанбаатар
хот

Зарим Байнгын хорооны даргыг сонгох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэгийг Монгол Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны даргаар, Монгол Улсын Их Хурлын гишүүн Бадрахын Найдалааг Монгол Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны даргаар тус тус сонгосугай.

2.Энэ тогтоолыг 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН
ДЭГЭЙН ХУРААЛТЫН

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 07 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 85

Улаанбаатар
хот

“Алт-3” аяныг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Алтны олборлолтыг нэмэгдүүлэх ба алт цэвэршүүлэх үйлдвэр барина” гэсэн зорилтыг хэрэгжүүлэх, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх, төлбөрийн тэнцлийн болон төгрөгийн ханшийн дарамтыг бууруулах, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасугай:

1/алт олборлолтын үйл ажиллагааг идэвхжүүлэх боломжит нөхцөлийг судалж, тогтвортой хөгжлийн зарчмыг баримтлан уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн баталгааг үндэслэн дэмжих;

2/хариуцлагатай уул уурхайг дэмжих хүрээнд эрдэс баялгийн салбарын оролцогч талуудын эрх, үүргийн харилцааг тодорхой болгож, төсөл хэрэгжиж байгаа суманд үр өгөөжийн дийлэнхийг үлдээх, хуулийн дагуу зөвшөөрөл авсан хөрөнгө оруулагч, аж ахуйн нэгжүүдийн хууль ёсны эрхийг хамгаалах, хууль бус шаардлага тавьж байгаа бусад оролцогч талуудад хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлж тодорхой болгох эрх зүйн орчныг сайжруулж, хууль тогтоомжийн төслийг боловсруулан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/алтыг хууль бусаар экспортлоход хил, гаалийн хяналтыг чангатгах;

4/геологийн судалгаа, эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх зорилгоор хайгуулын тусгай зөвшөөрлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн олон төрлөөр олгох зохицуулалтыг эрх зүйн орчинд тусгаж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төслийг боловсруулан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

5/гадаад валютын нөөцийг богино хугацаанд нэмэгдүүлж, үр өгөөж өгөх, Үндэсний баялгийн сангийн хуримтлалыг нэмэгдүүлэх боломжтой алтны үндсэн ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах, хилийн



заагт өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 46 дугаар тогтоол, “Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 47 дугаар тогтоолын холбогдох хавсралтад өөрчлөлт оруулах Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэх.

/Энэ дэд заалтад Монгол Улсын Ерөнхийлөгч 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдөр хэсэгчилсэн хориг тавьсан./

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Х.Ганхуяг/-нд даалгасугай.

3.Энэ тогтоолыг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

/Энэ заалтад Монгол Улсын Ерөнхийлөгч 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдөр хэсэгчилсэн хориг тавьсан./

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.АМАРБАЯСГАЛАН

کتابخانه عمومی

الحمد لله رب العالمين

53
 6211[illegible]

«سفر - ۳» سفر ن حسن كرمه حله سفره
سفره و حسن

[illegible][illegible][illegible][illegible][illegible][illegible]

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2025 оны 06 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар
хот

**Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай
хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг Монгол Улсын
Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг
хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн
хуралдааны танхим 16.30 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан /даргалагч/, Үндсэн хуулийн цэцийн гишүүн О.Мөнхсайхан, Э.Энхтуяа, Ц.Цолмон /илтгэгч/, Б.Болдбаатар нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн дарга Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Э.Болор-Эрдэнэ, О.Батхүү, Э.Тамир, С.Номынбаясгалан, түүний өмгөөлөгч З.Тамир болон Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, мөн шинжээчээр Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D) Б.Буянхишиг нар оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “... үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг тус тус зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

**Нэг. Монгол Улсын иргэн Э.Болор-Эрдэнэ Үндсэн хуулийн
цэцэд хандаж дараах агуулга бүхий мэдээлэл ирүүлжээ:**



“Монгол Улсад хууль ёсоор ажиллаж, амьдарч, эрх зүйн харилцаанд оролцож буй нийт иргэд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад заасан хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өөрийн дураар захиран зарцуулах эрхээ эдлэхэд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн газар болон үл хөдлөх хөрөнгийн үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй гэдэг заалт саад учруулж байна. Аливаа хөрөнгийн үнэлгээнд нөлөөлөх олон хүчин зүйлс байдгийн нэг буюу хамгийн түгээмэл нь цаг хугацааны эрхээр бий болж буй элэгдэл хорогдол юм. Тиймгүй байлаа ч хүн өөрийн өмчлөлийн эд хөрөнгийг хэрхэн захиран зарцуулах нь зөвхөн өмчлөгчийн эрхийн хүрээнд хамаарах зүйл бөгөөд Үндсэн хуулиар олгогдсон дээр дурдсан эрхэд бүдүүлгээр халдсан заалт байх тул хүчингүй болгож өгнө үү.” гэжээ.

Хоёр. Монгол Улсын иргэн О.Батхүү Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээлэл ирүүлжээ:

“Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг нь өмчлөгч өөрийн өмч хөрөнгийн үнийг чөлөөтэй тогтоох, захиран зарцуулах эрхийг хязгаарлаж, өмчлөгчийн эрхэд хууль бусаар халдах агуулгатай байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын Монгол Улсын иргэн хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй гэсэн агуулгатай нийцэхгүй байна.

Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална гэдэг зарчим өмчийн харилцааны үндэс суурийг тодорхойлохын зэрэгцээ өмчийн хэлбэр үл хамааран өмчлөгчдийн эрхийг тэгш хүндэтгэн хамгаалах төрийн үүргийг тодорхойлдог. Энэ нь төрөөс өмчлөлийн эрхийг баталгаажуулах, өмчийг ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагаанд хууль бус оролцоог хориглох, өмчлөгчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилготой юм. Гэтэл Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг нь иргэн, хуулийн этгээд өөрийн өмчлөлийн өмч хөрөнгөө чөлөөтэй захиран зарцуулах эрхийг хязгаарлаж, төр хувийн өмчийн харилцаанд хууль бусаар оролцож байгаа хэлбэр болж байна.

Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэж заасан. Энэ зарчим нь төрийн бүх шатны байгууллагаас гаргаж байгаа шийдвэр болон Улсын Их Хурлаас баталж байгаа хууль тогтоомж Үндсэн хуульд нийцсэн байх, иргэдийн эрхийг хамгаалах, тэдгээрийн эрхийг хууль бусаар хязгаарлахгүй байх үүрэг агуулгыг илэрхийлдэг. Гэтэл мэдээлэлд дурдаж байгаа хуулийн зохицуулалт өмчлөгчийн эрхийг хууль бусаар хязгаарлаж байгаа нь төрийн хууль дээдлэх зарчмыг зөрчиж байна.

Иймд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг Үндсэн хууль зөрчсөн болохыг тогтоож, уг заалтыг хүчингүй болгох дүгнэлт гаргаж өгнө үү.” гэжээ.

Гурав. Монгол Улсын иргэн С.Номынбаясгалан Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээлэл, нэмэлт тайлбар ирүүлжээ:

“Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй.” гэсэн нь хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх зэрэг үндсэн эрхийг хязгаарлахын зэрэгцээ өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болох Үндсэн хуулиар тогтоосон шаардлагыг хангахгүй байна. Учир нь өмчлөх эрх бол өмчлөгчийн язгуур эрх бөгөөд өмчлөгч өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах ба аливаа халдлагаас хамгаалах, хамгаалуулах эрхтэй. Хэдий тийм боловч өмчлөгчийн эрхийг гагцхүү нийтийн ашиг сонирхолд нийцүүлэх, бусдын эрхийг зөрчиж бусдад гэм хор учруулахыг хориглох, эд хөрөнгийн хязгаарлагдмал эрх бүхий этгээдэд эрхээ хэрэгжүүлэх боломж өгөх зорилгын үүднээс нийтийн болон иргэний эрх зүйн хэм хэмжээгээр хязгаарладаг нийтлэг жишиг байдаг. Гэтэл эдгээр дурдсан үндэслэлүүдийн аль нь ч бий болоогүй байхад эрхийн улсын бүртгэлд хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй байхаар дээрх хуульд зохицуулсан нь өнөөгийн үндэсний эдийн засгийн тогтолцооны суурь болох зах зээлийн эдийн засгийн үндсэн үзэл санаа, гол зарчимд нийцэхгүй, харин төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн утга агуулгыг илэрхийлсэн зохицуулалт болсныг харуулж байна.

Өөрөөр хэлбэл, хувийн эрх зүйн харилцаа нь тухайн харилцаанд оролцож буй субъектүүд өөрсдийн хүсэл зориг, саналыг харилцан зөвшилцсөний үндсэн дээр уг эрх зүйн үр дагаврыг хүсэж бий болгоход чиглэгдсэн байдгаараа онцлогтой. Гэтэл энэхүү харилцааны онцлог байдлыг харгалзан үзэхгүйгээр өмнө нь эрхийн улсын бүртгэлд бүртгүүлсэн үнээс хямдруулан үл хөдлөх эд хөрөнгийн үнийг зах зээл дэх эрэлт, нийлүүлэлтийг харгалзан бууруулан дараа нь үл хөдлөх эд хөрөнгөө худалдсан тохиолдолд тухайн үл хөдлөх эд хөрөнгийг худалсан гэрээг улсын бүртгэлийн байгууллага хүлээн авч бүртгэхгүй, нэр шилжихгүй болсон нь Монгол Улсын иргэн байна уу, эсхүл гадаадын иргэн байна уу, түүнчлэн нийслэл дэх үл хөдлөх хөрөнгө, эсхүл орон нутаг дахь үл хөдлөх хөрөнгө гэдгээс үл хамааран өөрийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгөө худалдан борлуулан эдийн засгийн үр шимийг нь хүртэх эрхийг нийтлэг байдлаар бүхэлд нь хязгаарласан байна. Тодруулбал, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд оруулсан дээрх маргаан бүхий зохицуулалтыг Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр баталсан Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуультай уялдуулан баталсан байдаг.



Үүнээс гадна, бүртгэлийн үйл ажиллагаа бол захиргааны чиг үүрэг, түүний шийдвэр, үйл ажиллагааны хэлбэрт хамаардаг тул Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл (Эрхийн улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах)-ийн 13.1 дэх хэсэгт “Дараах тохиолдолд эрхийн улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулна:” гээд 13.1.1 дэх заалтад “үл хөдлөх эд хөрөнгийн хэмжээ, үнэ, гүйцэтгэл өөрчлөгдөх;” гэсэн атлаа эрхийн улсын бүртгэлд хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй гэж императив шинжтэйгээр улсын бүртгэгчид үүрэгжүүлэн нийтлэг байдлаар зохицуулсан нь эрхийн улсын бүртгэлийн суурь зарчимд харшилж байна. Үүнээс улбаалан захиргааны чиг үүрэг, түүний шийдвэр, үйл ажиллагаанд зайлшгүй баримтлах ёстой Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмууд болох хууль дээдлэх, эрх чөлөө зэрэгт төдийгүй Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт заасан захиргааны үйл ажиллагаанд баримтлах тусгай зарчмуудын үндсэн агуулгад нийцэхгүй байна.

Иргэний хууль тогтоомжоор тодорхойлсон улсын бүртгэлд бүртгүүлэх эрх зөрчигдсөн талаар, Иргэний хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, 109 дүгээр зүйлийн 109.1, 110 дугаар зүйлийн 110.1, 182 дугаар зүйлийн 182.1, 182.3 дахь хэсэгт зааснаас үзвэл улсын бүртгэлд бүртгүүлэх эрхийг Иргэний хууль тогтоомжоор тодорхойлсон байна. Уг зохицуулалтаар өмчлөх эрхийг хэрхэн олж авах асуудлыг тусгасан. Иргэний хуулийн 109, 110 дугаар зүйлд зааснаар өмчлөх эрх шилжих үе нь шийдвэрлэх ач холбогдолтой төдийгүй үл хөдлөх эд хөрөнгийн хувьд үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгүүлсэн үе байхаар байна. Тухайлбал, өмчлөх эрх олж авах үйл явц бүрэн дуусгавар болох үеийг тогтоосон бөгөөд өмчлөх эрх олж авч байгаа этгээдийг өмчлөгчөөр үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн цаг мөч нь шийдвэрлэх ач холбогдолтойг Иргэний хуулийн 110 дугаар зүйлийн 110.1 дэх хэсэгт заасан байна. Энэ үед худалдагчийн өмчлөх эрх зүй ёсоор дуусгавар болох юм.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Иргэн, хуулийн этгээд Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 8.1.1-д заасан эрхийг хуульд заасан журмын дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлснээр өмчлөх эрх үүснэ.”, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Иргэн, хуулийн этгээд Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 8 дугаар зүйлд заасан эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх тухай мэдүүлгийг тухайн үл хөдлөх эд хөрөнгө оршин байгаа нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу улсын бүртгэлийн байгууллагад гаргана.”, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Улсын бүртгэгч дараах үндэслэлээр мэдүүлгийг хүлээн авахаас татгалзана:” гээд 8.1.2-8.1.6 дахь заалтад мэдүүлэг хүлээн авахаас татгалзах үндэслэл нэг бүрийг нарийвчлан заасан байна.

Мөн уг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн шилжилтийг эрхийн улсын бүртгэлд бүртгэхэд зайлшгүй шаардлагатай

мэдээллийн жагсаалтыг дурдахын зэрэгцээ, мөн зүйлийн 11.9 дэх хэсэгт “Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх шилжиж байгаа бол холбогдох баримт бичгийн эх хувийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор эрхийн улсын бүртгэлд зохих өөрчлөлт оруулах эсэхийг шийдвэрлэж, энэ тухай мэдүүлэг гаргагчид бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх бөгөөд өөрчлөлт орсноор шинэ өмчлөгчийн өмчлөх эрх үүснэ.” гэж шинэ өмчлөгчийн өмчлөх эрх хэрхэн үүсэх асуудлыг хуульчилсан байна. Харин Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт эрхийн улсын бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах тодорхой тохиолдол нэг бүрийг нэрлэн заасан байна.

Дүгнэвэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг нь улсын бүртгэлд бүртгүүлэх эрхийг хязгаарласан шинжтэй төдийгүй хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулахгүй гэх үнийн босго тогтоосноор үл хөдлөх эд хөрөнгийн өмнөх өмчлөгчийн, эсхүл шинэ өмчлөгчийн аль алиных нь үл хөдлөх эд хөрөнгө олж авах, захиран зарцуулах зэрэг өмчлөх эрх зөрчигдөхөд хүргэсэн гэж үзэх хууль зүйн үндэслэлтэй байна.

Гэрээний чөлөөт байдлын зарчим зөрчигдсөн талаар, Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт “Иргэний хууль тогтоомж нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчимд үндэслэнэ.”, 189 дүгээр зүйлийн 189.1 дэх хэсэгт “Гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй.” гэж гэрээний чөлөөт байдлын зарчмыг тодорхойлсон байна. Уг зарчмын Үндсэн хуулиас үүдэлтэй үндэслэл нь гэрээний эрх чөлөө буюу амьдралынхаа харилцааг гэрээний үндсэн дээр бие даан тодорхойлох хувь хүний үндсэн эрх, эрх чөлөөний илрэл гэдэгт оршиж байна. Тодруулбал, Иргэний хуулийн 195 дугаар зүйлийн 195.1, 195.2, 195.3 дахь хэсэгт гэрээний гол нөхцөлийн талаар дурдсан бөгөөд үүнд худалдан борлуулагдах үл хөдлөх эд хөрөнгийн үнийг хэрхэн тогтоох, уг үнийг зах зээл дэх эрэлт, нийлүүлэлтээр тодорхойлох уу, эсвэл тухайн нөхцөл байдал дахь үл хөдлөх эд хөрөнгийн хуучин болон шинэ өмчлөгчдийн харилцан тохиролцоо зэргээр үнийг тогтоох асуудлыг авч үзэх учиртай. Маргаан бүхий зохицуулалтад эрхийн улсын бүртгэлд хамгийн сүүлд бүртгэгдсэн үнийг бууруулах бус харин байнгын өсгөх агуулгаар тусгасан нь гэрээний чөлөөт байдлын зарчимд сөргөөр нөлөөлөхүйц, түүнд харшилсан шинжтэй зохицуулалт болсныг харуулж байна.

Төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим зөрчигдсөн талаар, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад зааснаар хууль тогтоогч хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах онцгой бүрэн эрхтэй хэдий ч уг эрхээ Үндсэн хуулийн Нэгдүгээр



зүйлд тодорхойлсон төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын хүрээнд хэрэгжүүлэх учиртай. Энэ утгаар авч үзвэл хууль тогтоогч үл хөдлөх эд хөрөнгийн үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй байхаар хуульчилсан нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болох хууль дээдлэх зарчмын суурь болсон Үндсэн хууль дээдлэх зарчмын үзэл санаа, агуулга болон эрх чөлөөний зарчмын суурь болсон хүний эрх, эрх чөлөөний үзэл санаа, үндсэн эрх, эрх чөлөөний агуулга болон гол зарчим хоорондын уялдаа холбоо, тэнцвэрийг алдагдуулсан маргаан бүхий зохицуулалт бий болгосон байна.

Иймд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байх тул хянан хэлэлцэж хүчингүй болгож өгнө үү.” гэжээ.

Дөрөв. Монгол Улсын иргэн Э.Тамир Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээлэл ирүүлжээ:

“Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг нь иргэний өмчлөх эрхэд халдсан төдийгүй өмч хөрөнгөө зарж чадахгүй байх нөхцөл байдалд хүргэсэн байна. Тодруулбал, бодит амьдрал дээр мөнгөний зайлшгүй хэрэгцээ шаардлага үүссэн тохиолдолд иргэн өөрийн үл хөдлөх хөрөнгө болох газар, орон сууц гэх мэт зүйлээ өмнө нь худалдан авсан үнээсээ хямдруулан зарах боломжийг дээрх зохицуулалтаар тухайн үл хөдлөх эд хөрөнгийг анх авсан үнээр, эсвэл түүнээс дээш үнээр зарахгүй бол улсын бүртгэл дээр нэрийг нь шилжүүлэхгүй байх сөрөг үр дагавар бий болгож хязгаарлаж байна. Өөрийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгөө хэнд, ямар үнээр худалдан борлуулах нь тухайн иргэний өөрийн санхүүгийн эрх чөлөөтэй холбоотой үндсэн эрх байх учиртай. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт, түүний үзэл санаа, агуулга зэрэгт нийцэхгүй байна. Ингэснээр төр иргэнийхээ өмнө хүлээсэн нийгэм, эдийн засаг, хууль зүйн баталгаа зэргийг бүрдүүлэх үүргээ биелүүлээгүй болохыг харуулж байна.

Иймд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “... үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх ... эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг тус тус зөрчсөн байх тул хянан хэлэлцэж, хүчингүй болгож өгнө үү.” гэжээ.

Тав. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалаас Үндсэн хуулийн цэцэд хандан дараах тайлбарыг ирүүлжээ. Үүнд:

“Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийг Улсын Их Хурал 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр батлахад хамт өргөн мэдүүлсэн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар тус хуулийн 9 дүгээр зүйлийг бүхэлд нь өөрчлөн найруулсан бөгөөд Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулиар зохицуулж буй нэг чухал харилцаа нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх явдал болно. Тус хуульд нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөхөд нөхөх олговрын хэд хэдэн хэлбэрийг ашиглахаар тусгасан бөгөөд уг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт газрыг газраар дүйцүүлэн олгох; газрыг үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгөөр дүйцүүлэн олгох; газрыг нөхөх олговрын мөнгөн хэлбэрээр худалдан авах; боломжит бусад гэсэн дөрвөн хэлбэрийг заажээ. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй.” гэж заасан нь газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртөж байгаа этгээдийн газрыг нөхөх олговрын мөнгөн хэлбэрээр худалдан авах тохиолдолд түүний хамгийн сүүлд бүртгэгдсэн үнийг жишиг болгон харгалзан үзэх, түүнээс бууруулахгүйгээр нөхөх олговрын хэмжээг тогтоох боломжийг олгож байна. Улмаар газар чөлөөлөлтийн нөлөөлөлд өртөж байгаа иргэн, хуулийн этгээдийн газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.4 дэх заалтад заасан газар, үл хөдлөх эд хөрөнгийн нөхөх олговрын зориулалттай үнэлгээний аргачлалын дагуу үнэлгээ хийх тусгай зөвшөөрөлтэй этгээдээр төрийн зардлаар хийлгэх, эсхүл өөрийн зардлаар хийлгэж болохоор зохицуулсан бөгөөд эдгээр нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасантай нийцэж байгаа болно.

Иргэний хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт зааснаар өмчлөгч нь бусад этгээдэд хууль буюу гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр, хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах эрхтэй бөгөөд аливаа халдагаас хамгаалах эрхтэй. Тодруулбал, өмчлөгч өөрийн өмчлөлийн зүйлийн хувь заяаг бүрэн шийдвэрлэх туйлын эрхтэй буюу өмчлөлийн зүйлээ бусдын өмчлөл, эзэмшилд хариу төлбөртэй буюу төлбөргүй шилжүүлэх бүрэн эрхтэй. Харин Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт энэхүү эрхийг хязгаарласан аливаа зохицуулалт тусгагдаагүй бөгөөд өмчлөлийн зүйлийн хувь заяаг бүрэн шийдвэрлэх туйлын эрхэд аливаа хэлбэрээр халдаагүй болно. Эд хөрөнгөө захиран зарцуулах эрхийн тухайд өмчлөгч аливаа этгээдтэй иргэний эрх зүйн харилцаанд оролцох нь нээлттэй бөгөөд гэрээний талуудын чөлөөт байдлын зарчимд үндэслэн хүсэл зоригоо илэрхийлж хийсэн хэлцлээ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлж эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэхэд



ямар нэг хориглолт, хязгаарлалт тавигдаагүй болно. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт эрхийн улсын бүртгэлд үл хөдлөх эд хөрөнгийн үнийг хэрхэн тусгах харилцааг зохицуулж байгаа бөгөөд үүнийг өмчлөгчийн эрхийг хязгаарлаж буй хэлбэр гэж үзэх нь учир дутагдалтай юм.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад заасныг хангахад чиглэсэн заалт болно. Үүнийг тайлбарлавал тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтад “өмчлөх эрх болон түүнтэй холбогдсон эд хөрөнгийн бусад эрх, газрын эрхийг худалдах, эсхүл шилжүүлэн бүртгүүлэх тохиолдолд гэрээ, хэлцэл, эсхүл эрх шилжүүлсэн шийдвэрт тусгагдсан үнэ;”, 9.1.4 дэх заалтад “газрын эрх, үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалах тохиолдолд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн барьцааны гэрээ, эсхүл барьцаалбарт тусгагдсан тухайн эд хөрөнгийн барьцааны үнэ;” гэж заасан бөгөөд иргэний эрх зүйн хоёр төрлийн харилцаанд хамаарах нөхцөлийг хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт тодотгож өгчээ.

Эхний тохиолдолд буюу өмчлөх эрх болон түүнтэй холбогдсон эд хөрөнгийн бусад эрх, газрын эрхийг худалдах, эсхүл шилжүүлэн бүртгүүлэх тохиолдолд тухайн эд хөрөнгийг худалдагч талыг хууран мэхлэх замаар үл хөдлөх эд хөрөнгө борлуулж, худалдаалдаг ченж гэх тодотголтой этгээдүүд зах зээлийн ханшаас хэт бага үнээр үл хөдлөх эд хөрөнгийг нь үнэлж худалдан авах, улмаар үнэ нэмж хэт өндөр үнээр борлуулах, дамжуулан худалдах тохиолдол цөөнгүй гарч байсан. Иймд дээрх зохицуулалтыг бий болгосноор хөрөнгийн үнэлгээ хийх эрх бүхий этгээдээр үнийг бодитой тогтоолгосноор өмчлөгч этгээд үл хөдлөх эд хөрөнгөө худалдан борлуулах, эд хөрөнгөөрөө хохирох бодит эрсдэлийг хааж өгсөн болно. Түүнчлэн үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогод ногдуулах албан татварыг бага хувь хэмжээгээр төлөх зорилгоор гэрээний үнийн дүнг зориуд бууруулж тогтоох үзэгдэл түгээмэл гарах болсон. Энэ нь нэг талдаа хуулиар ногдуулсан албан татвараа шударгаар төлөх иргэний үндсэн үүргээ биелүүлэх, нөгөө талдаа тухайн гэрээнээс татгалзсан, эсхүл түүнийг хүчингүй болгосон тохиолдолд гэрээгээр тохиролцсон үнийн дүнгээр хохирлоо барагдуулах иргэний эрхийг хамгаалж буй хэрэг юм.

Хоёр дахь тохиолдолд өмчлөгч этгээд газрын эрх, үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалахдаа мөнхүү дээрхтэй адил шалтгаанаар банк, банк бус санхүүгийн байгууллага болон бусад этгээд тухайн эд хөрөнгийг зах зээлийн бодит үнээс доогуур үнэлж зээл олгох, бага хэмжээний зээл дээр өндөр үнэлгээ бүхий үл хөдлөх эд хөрөнгийг нь барьцаалах замаар гэрээ байгуулахаас сэргийлсэн. Тодруулбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.” гэж заасныг хэрэгжүүлж буй хэлбэр болно.

Энэхүү тайлбарт дурдсанчлан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг нь өмчлөгчийн эрхийг хязгаарласан агуулгагүй бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж заасантай нийцүүлж өмчлөгчийн хууль ёсны ашиг сонирхол, нийтлэг эрх ашгийг хамгаалах, тэнцвэржүүлэхэд чиглэж төрөөс авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ гэж үзэх үндэслэлтэй юм. Үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл нь үл хөдлөх эд хөрөнгийн талаар хэлцэл хийгч талууд хамгийн сүүлийн үеийн, үнэн зөв мэдээллийг энэхүү бүртгэлээс олж авна гэсэн итгэл үнэмшилтэйгээр арилжаа, бизнесийн харилцаанд орох боломжийг төрөөс олгож байгаа хэлбэр юм. Тиймээс үүнийг хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэхэд чиглэсэн зохицуулалт гэж ойлгож хэрэглэх нь зөв бөгөөд практик дээрх хууль хэрэглээний асуудлыг нэг мөр, ойлгомжтой болгох зарим шаардлага байхыг үгүйсгэхгүй юм.

Иймд дээрх үндэслэлээр Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “... үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх ... эрхтэй. ...”, мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг зөрчөөгүй гэж үзэж байна.” гэжээ.

Зургаа. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад мэдээлэл гаргагч иргэн С.Номынбаясгалан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг мөн зөрчсөн байна гэж мэдээллийн шаардлагаа нэмэгдүүлж байна гэсэн боловч холбогдох тайлбар, үндэслэлээ дурдаагүй болно.

Долоо. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд бэлтгэх хүрээнд Улсын Их Хурлын Тамгын газраас хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлал, холбогдох Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэл, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газраас тайлбар, тодруулга, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D) Б.Баянхшигээр шинжээчийн дүгнэлт тус тус гаргуулан авч, Үндсэн хуулийн цэцийн Судалгааны төвөөр судалгаа хийлгэсэн болно.



ҮНДЭСЛЭЛ:

1.Монгол Улсын Үндсэн хууль (цаашид “Үндсэн хууль” гэх)-ийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад заасны дагуу хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсын Их Хурал (цаашид “Улсын Их Хурал” гэх)-аас 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийг баталсан байх бөгөөд энэ хуультай холбогдуулан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, уг хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг “Энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй.” гэж өөрчлөн найруулсан байна.

2.Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.” гэж заажээ. Өмчлөх эрх нь Үндсэн хуульд тухайлан заасан иргэний үндсэн эрхийн нэг бөгөөд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “... үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх ... эрхтэй. ...” гэж баталгаажуулжээ. Иргэний хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсэгт заасны дагуу өмчлөгч нь бусад этгээдэд хууль буюу гэрээгээр олгогдсон эрхийг зөрчихгүйгээр, хуулиар тогтоосон хэмжээ, хязгаарын дотор өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах бөгөөд аливаа халдлагаас хамгаалах эрхтэй байна. Өмчлөгч нь өмчлөлийн зүйлээ өөрийн мэдэлд байлгаж, түүний ашиг, үр шимийг хүртэх, өмчлөлийн эд хөрөнгөө чөлөөтэй захиран зарцуулах эрхтэй боловч энэ эрх нь туйлын эрх биш юм. Уг эрх нь нийтийн ашиг сонирхлоор хязгаарлагдах бөгөөд хязгаарлалт нь хуулиар тусгайлан зохицуулсан тодорхой хэм хэмжээнд үндэслэгдсэн байх ёстой.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтын үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх эрхийн хэрэгжих гол хэлбэр нь хэлцэл буюу гэрээ юм. Гэрээний эрх чөлөөний агуулга нь хүн бүр гэрээ байгуулах эсэхээ чөлөөтэй шийдэх ба гэрээ байгуулах тал, гэрээний агуулгыг өөрөө тодорхойлох эрхтэй бөгөөд иргэний эрх зүйн харилцааны үндсэн зарчим юм. Уг зарчим нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад заасан хөрөнгө чөлөөтэй олж авах үндсэн эрхийг хэрэгжүүлэх суурь болдог. Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт “Иргэний хууль тогтоомж нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш, бие даасан байдал, өмчийн халдашгүй байдал, гэрээний эрх чөлөө, ... хөндлөнгөөс оролцохгүй байх, иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх ... зарчимд үндэслэнэ.”, мөн хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1 дэх хэсэгт “Гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй.” гэж гэрээний эрх чөлөөг бататган хуульчилсан байна.

Иймд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг (цаашид “маргаан бүхий зохицуулалт” гэх) нь Монгол Улсын иргэн үл хөдлөх эд хөрөнгө шударгаар олж авах, өмчлөх эрхээс гадна иргэний эрх зүйн харилцаанд оролцогч өөрийн хүсэл зоригийн дагуу чөлөөтэй гэрээ байгуулах, эд хөрөнгийн харилцаанд оролцох эрхийг хязгаарласан зохицуулалт болжээ.

3.Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх ...” нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим гэж заасан. Үндсэн хуулиар баталгаажсан иргэний үндсэн эрхийг хуулиар хязгаарлаж байгаа тохиолдолд эрх зүйн тодорхой байдал, түүнчлэн тохирсон байх зарчмыг хангаж байж хууль дээдлэх зарчимд нийцсэн хязгаарлалт болох юм. Үндсэн эрхийн хязгаарлалт нь эдгээр зарчмыг хангасан эсэхийг шалгахад дараах нөхцөл байдал тогтоогдож байна:

3.1. Эрх зүйн тодорхой байдлын зарчмыг хангасан эсэх:

Үндсэн хуулиар баталгаажсан иргэний үндсэн эрхийг хязгаарласан хууль нь эрх зүйн тодорхой байдлын зарчимд нийцсэн байхыг шаардана. Уг зарчим нь үндсэн эрхийг гагцхүү хуулиар хязгаарлах, уг хязгаарлалт нь хоёрдмол утгагүй, тодорхой ойлгогдохоор байх, зохицуулалтаас үүдэх үр дагаврыг урьдчилан таамаглаж мэдэх боломжтой байх, ингэснээр иргэд зан үйлээ түүнд нийцүүлэх боломжтой байдлаар хуульчлахыг шаарддаг.

Маргаан бүхий зохицуулалтад “Энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй.” гэж өмчлөх эрх болон түүнтэй холбогдсон эд хөрөнгийн бусад эрх, газрын эрхийг худалдах, эсхүл шилжүүлэн бүртгүүлэх тохиолдолд гэрээ, хэлцэл, эсхүл эрх шилжүүлсэн шийдвэрт тусгагдсан үнэ; газрын эрх, үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалах тохиолдолд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн барьцааны гэрээ, эсхүл барьцаалбарт тусгагдсан тухайн эд хөрөнгийн барьцааны үнээр эрхийн улсын бүртгэлд үл хөдлөх эд хөрөнгийн үнийг тусгах бөгөөд дээрх үнэд орсон өөрчлөлтийг хуульд заасны дагуу хөрөнгийн үнэлгээ хийх эрх бүхий этгээдээр тогтоолгосноос бусад тохиолдолд хамгийн сүүлд эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн үнээс бууруулан бүртгэхгүй байхаар хуульчилсан байна.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “Энэ хууль Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот /цаашид “нийслэл хот” гэх/-ын нутаг дэвсгэрт үйлчилнэ.” гэсэнтэй маргаан бүхий хуулийн зохицуулалтын хамрах хүрээ нийцэхгүй, Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд үйлчилж байгааг дурдах нь зүйтэй.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр ирүүлсэн “Мэдээлэл хүргүүлэх тухай” албан бичигт дээрх



хуулийг дагаж мөрдөж эхэлснээс хойш өдөрт дунджаар улсын бүртгэлийн нэг нэгж дээр 5-6 иргэн, нийслэлд 50-60 иргэн, орон нутагт 25-26 иргэн, улсын хэмжээнд 80-90 иргэн зөвхөн эд хөрөнгийн үнэтэй холбоотой хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөс шалтгаалан бүртгэлээ хийлгэх боломжгүй буцах тохиолдол гарч байгаа талаар тэмдэглэжээ. Түүнчлэн Улсын Их Хурлаас 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталсан Нотариатын тухай хуулийн дагуу эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж гэрээ, хэлцэл байгуулахаар иргэн, хуулийн этгээдээс хүсэл зориггоо илэрхийлсэн тохиолдолд маргаан бүхий хуулийн зохицуулалт нь нотариатын үйлдэл гэрчлэхээс татгалзах хуулийн үндэслэлд хамаарч байгаа тул эрхийн бүртгэлийн өмнөх шатанд ийм гэрээ, хэлцлийг нотариатаар гэрчлүүлж чадахгүй байгаа тохиолдол цөөнгүй байгаа нь тогтоогдож байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн зохицуулалт нь газар өмчлөх эрх, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх худалдах, шилжүүлэх тохиолдолд үйлчилж байгаа боловч хуульд заасан бусад тохиолдолд буюу газар эзэмших, ашиглах эрх худалдах, шилжүүлэх, газрын эрх, үл хөдлөх эд хөрөнгө барьцаалах зэрэг харилцаанд зохих ёсоор үйлчлэхгүй байгаа нь нотлох баримтаар тогтоогдож байна.

Өмчлөгч нь өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй захиран зарцуулах эрхтэй бөгөөд өмчлөлийн зүйлийн үнийг өөрөө тогтоох эрхтэй. Өмчлөгчийн эрхийг хуульд заасан үндэслэлээр нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хязгаарлаж болно. Энэ тохиолдолд хуулийн зохицуулалт нь тодорхой байх, түүнийг хэрэгжүүлэх журмыг тухайлан хуульчилсан байх ёстой. Маргаан бүхий хуулийн зохицуулалттай уялдуулан “газрын эрх” “улсын бүртгэлд бүртгэгдсэн барьцааны гэрээ, эсхүл барьцаалбарт тусгагдсан тухайн эд хөрөнгийн барьцааны үнэ” зэрэг зохицуулах зүйлийн хувьд олон талтай, хамрах хүрээ нь өргөн томьёоллыг хууль тогтоогч хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгаж өгсөн боловч тодорхой зохицуулалтыг хуульчилж өгөөгүйгээс хуулийн үйлчлэлд хамаарч байгаа иргэд, хуулийн этгээдийн дунд төдийгүй хууль хэрэгжүүлэх төрийн байгууллага, албан тушаалтны хувьд тодорхойгүй байдлыг бий болгосон нь тайлбар, мэдээлэл бусад нотлох баримтаар тогтоогдож байна.

Өмчлөгч нь өөрийн өмчлөлийн газар, үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэгдсэн үнээс бууруулан бусад худалдах, шилжүүлэх тохиолдолд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтад зааснаар үнийн талаар өөрчлөлт орсныг эрхийн улсын бүртгэлд бүртгэхэд хуульд заасны дагуу хөрөнгийн үнэлгээ хийх эрх бүхий этгээдээр үнэ тогтоолгож болохоор хуульчилсан байна. Улсын Их Хурлаас 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр баталсан Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.14 дэх заалтад ““хөрөнгийн үнэлгээ хийх” гэж тодорхой зорилгод нийцүүлэн хөрөнгийн үнэлгээний

зүйлийн үнэ цэнийг тогтоох хараат бус үйл ажиллагааг” ойлгоно гэжээ. Хуульд зааснаар тусгай зөвшөөрөл бүхий үнэлгээчинтэй гэрээ байгуулан хөлс төлж үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ хийлгэдэг. Сангийн сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн А/133, А/126 дугаар хамтарсан тушаалаар “Үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ хийх аргачлал”-ыг баталсан бөгөөд уг аргачлалын 4.1 дэх заалтад “Үнэлгээчин нь зах зээлийн, орлогын, өртгийн хандлагын тохиромжтой аргыг ашиглан хөрөнгийн үнэ цэнийг тооцоолно.” гэж заасан. Үл хөдлөх эд хөрөнгийн үнэ цэн болон үнэ гэдэг нь ялгаатай ойлголт бөгөөд хоорондоо хамааралтай байж болох ч давхцахгүй. Үл хөдлөх эд хөрөнгийн үнэ цэн нь зах зээлийн болон бусад олон хүчин зүйлээс шалтгаалдаг бөгөөд өмчлөгчийн хүсэл зоригоос хамааралгүй бол, үл хөдлөх эд хөрөнгийг худалдах үнэ нь өмчлөгчийн хүсэл зоригоос шууд хамааралтай байдаг. Түүнчлэн хөрөнгийн үнэлгээчин тооцоолон гаргасан тухайн газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнэ цэн нь талуудын хооронд тохирсон гэрээний үнийн дүнгээс өөр тохиолдолд улсын бүртгэл хийх эсэх нь тодорхойгүй байгаагаас албан тушаалтан өөрийн үзэмжээр энэхүү хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх нөхцөл байдлыг бий болгожээ.

3.2. Тохирсон байх зарчмыг хангасан эсэх:

Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйл болон Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад заасны дагуу “үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх” эрхийг хязгаарласан зохицуулалт нь тохирсон байх зарчимд нийцсэн байхыг шаардана. Энэ зарчмын дагуу маргаан бүхий хуулийн зохицуулалтаар тогтоосон хязгаарлалт нь хууль ёсны зорилготой байх, хууль ёсны зорилго болон хуулийн зохицуулалт нь уялдаатай байх, зайлшгүй байх, хязгаарлагдаж байгаа үндсэн эрх болон нийтийн ашиг сонирхол тэнцвэртэй байх гэсэн шалгуурыг хангасан эсэхийг шалгахад дараах нөхцөл байдал тогтоогдож байна:

3.2.1. Хууль ёсны зорилготой, уялдаатай эсэх:

Үндсэн эрхийн хязгаарлалт тогтоосон хуулийн зохицуулалт нь тохирсон байх зарчимд нийцэх ёстой бөгөөд үүний тулд хууль ёсны зорилготой, уг зорилго болон хуулийн зохицуулалт нь уялдаатай байх ёстой.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь иргэний саадгүй зорчих нөхцөлийг нэмэгдүүлэх, нийтийн тээврийн төрөл, хүртээмж, авто зогсоолын ашиглалтыг сайжруулах, хотын төвлөрлийг сааруулж, гэр хорооллыг орон сууцжуулах, түгжрэл, орчны бохирдлоос үүсэх нийгэм, эдийн засгийн нөлөөллийг бууруулахад оршино.” гэсэнтэй маргаан бүхий хуулийн зохицуулалт уялдахгүй байна.



Мөн хуулийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгад энэхүү зохицуулалтыг “эрхийн улсын бүртгэлд тусгах газрын хязгаарлагдмал эрх, гэрээгээр ашиглах эрх, үл хөдлөх эд хөрөнгийн үнийг тодорхойлох үндэслэл, дэс дарааллыг бодитой болгон зохицуулалтыг өөрчлөх” зорилгоор боловсруулсан гэж тусгасан байна. Харин Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгчийн тайлбарт үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогод ногдуулах татварыг бага хувь хэмжээгээр төлөх зорилгоор гэрээний үнийн дүнг зориуд бууруулж тогтоох үзэгдэл түгээмэл гарах болсон бөгөөд татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор хуулийг баталсан гэжээ.

Үндсэн эрхийн хязгаарлалт нь Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээн зөвшөөрөгдсөн үнэт зүйлийг хамгаалах зорилготой байх ёстой. Ийм шаардлагыг хангаж байж зүй ёсны шинжтэй болдог. Иймд “... үл хөдлөх эд хөрөнгийн үнийг тодорхойлох үндэслэл, дэс дарааллыг бодитой болгон зохицуулалтыг өөрчлөх” гэснийг хууль ёсны зорилго гэж үзэх боломжгүй. Харин Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 29 дүгээр зүйлд тухайлан зааснаар нийтийн ашиг сонирхлыг хангах зорилгоор үндсэн эрхийг хуулиар хязгаарлах боломжтой гэсэн зохицуулалтын хүрээнд татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор энэхүү хуулийг батлах боломжтой. Иймд хууль ёсны зорилго болон маргаан бүхий хуулийн зохицуулалт хоорондоо уялдаатай гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

3.2.2.3.Зайлшгүй эсэх:

Зайлшгүй байх шалгуур нь Үндсэн хуулиар баталгаажсан үндсэн эрхийг хязгаарлахгүйгээр, эсхүл илүү бага хязгаарлах өөр аргаар хууль ёсны зорилгод хүрэх боломжтой байсан эсэхийг тодруулах ёстой.

Улсын Их Хурлаас 2019 оны 3 сарын 22-ны өдөр баталсан Татварын ерөнхий хуулиар Монгол Улсад татвар бий болгох, тогтоох, татвар төлөгчийг бүртгэх, татвар ногдуулах, тайлагнах, төлөх, хянан шалгах, хураах, хөнгөлөх, чөлөөлөх, суутган тооцох, буцаан олгох эрх зүйн үндсийг тогтоон Монголын Татварын алба, татвар төлөгч болон энэ хуулийн дагуу татварын албаны өмнө үүрэг хүлээсэн бусад этгээдийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлон, тэдгээрийн хооронд үүсэх харилцааг зохицуулсан. Хүчин төгөлдөр үйлчилж буй Татварын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журмын хүрээнд энэ төрлийн татвараас зайлсхийх явдлыг таслан зогсоох боломжтой бөгөөд шаардлагатай бол үндсэн эрхийг хязгаарлахгүйгээр татварын хууль тогтоомжид тохирсон нэмэлт, өөрчлөлт оруулах замаар уг асуудлыг шийдвэрлэх боломжтой.

Сангийн сайдаас 2024 оны 6 дугаар сарын 06-ны өдөр ирүүлсэн “Тайлбар хүргүүлэх тухай” албан бичигт “Үл хөдлөх эд хөрөнгийн албан

татварын тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн дагуу зөвхөн мэдүүлэг гаргагчийн анх мэдүүлсэн үнээр татвар тооцогддог, цаашид худалдах, худалдан авах гэрээ хийх, барьцаалах зэргээр зах зээлийн үнэлгээ шинэчлэгдэхэд үүний дагуу холбогдох үнэлгээ татварын ногдол шинэчлэгдэхгүй байснаар Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад заасан татварын шударга байх зарчим алдагдахад хүрсэн.” гэсэн байна. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулиар үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын харилцааг зохицуулах нь зохимжгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд Үндсэн хуулиар баталгаажсан хүний үндсэн эрхийг хязгаарлахгүйгээр Татварын ерөнхий хууль болон Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд тусгайлан өөрчлөлт оруулах замаар дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх боломжтойг дурдах нь зүйтэй.

3.2.3.Тэнцвэртэй эсэх:

Хууль ёсны зорилгод хүрэхийн тулд маргаан бүхий хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлснээр нийтийн ашиг сонирхол тус үндсэн эрхийн хязгаарлалт харилцан тэнцвэртэй байх ёстой. Хуулийн үйлчлэлээс гарах үр дагаварт анхаарал хандуулснаар энэхүү шалгуур хангагдсан эсэхийг тодруулна.

Маргаан бүхий хуулийн зохицуулалтын дагуу хуулийн үйлчлэлд хамаарч байгаа иргэд өөрийн хүсэл зоригийн дагуу байгуулсан гэрээ, хэлцлийг нотариатаар гэрчлүүлэх боломжгүй байх, улсын бүртгэлд бүртгүүлэх төрийн үйлчилгээ авч чадахгүй байхаас гадна, зөвхөн эрх бүхий үнэлгээчнээр хөрөнгийн үнэлгээг хийлгүүлж, эд хөрөнгийн үнэ цэнийг тогтоолгосны үндсэн дээр өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлэхээр зохицуулжээ. Түүнчлэн тухайн газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнэ цэн нь талуудын тохирсон гэрээний үнээс өөр байгаа тохиолдолд улсын бүртгэлд бүртгүүлж болох эсэх, гэрээний үнээр нь бүртгэл хийх, эсхүл үнэлгээчний тогтоосон үнэ цэнээр нь бүртгэл хийх нь тодорхойгүй байгаа бөгөөд улсын бүртгэлийн албан тушаалтан дур мэдэн өөрийн үзэмжээр хуулийг хэрэгжүүлэх боломжийг бий болгосон байна. Мөн Үндсэн хуулийн цэцийн хуралдааны явцад мэдээлэл гаргагчид тайлбартаа “маргаан бүхий зохицуулалтад хамаарч байгаа иргэд өмчлөлийн зүйлийн үнийг улсын бүртгэлд бүртгүүлсэн үнээс бууруулж борлуулахын тулд өөрт нь бага хохиролтой бол хуурамчаар гэрээний үнийг ихэсгэн гэрээ байгуулах явдал гарах болсон” гэснийг дурдах нь зүйтэй байна.

Иймд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг нь Үндсэн хуульд заасан үндсэн эрхийг хууль ёсны зарчимд нийцэхгүй байдлаар хязгаарласан, иргэдээс цаг хугацаа, илүү зардал шаардсан, нэг мөр хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, тодорхойгүй зохицуулалт болох нь тогтоогдож байна.



Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч болон Сангийн сайд, Татварын ерөнхий газраас ирүүлсэн тайлбарт маргаан бүхий хуулийн зохицуулалт нь үл хөдлөх эд хөрөнгийн болон хувь хүний орлогын албан татвараас зайлсхийх явдлаас сэргийлэх ач холбогдолтой гэсэн боловч татварын хууль тогтоомжоор зохицуулах харилцааг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хууль тогтоомжоор зохицуулахыг оролдсон нь хууль тогтоомжийн тодорхойгүй байдлыг бий болгосноос гадна, хууль батлагдсанаар хүссэн үр дүн гарсан эсэх, хуулийн заалт нь зорилгодоо хүрсэн эсэх нь тогтоогдохгүй байна.

Түүнчлэн, татвар төлөхөөс зайлсхийхээс урьдчилан сэргийлэхийн тулд үл хөдлөх хөрөнгө өмчлөгч бүрийн өмчөө захиран зарцуулах эрхийг хязгаарласан нь тэнцвэртэй байх шалгуурыг хангаагүй байна. Өөрөөр хэлбэл, татвар төлөхөөс зайлсхийх эрсдэлтэй татвар төлөгчийн зөрчлийг арилгахын тулд бусад өмчлөгчийн өмчлөх эрх болон өмчөө чөлөөтэй захиран зарцуулахтай холбоотой гэрээний эрх чөлөөнд хязгаарлалт бий болгосноор тэнцвэртэй байх шалгуур алдагдсан байна.

Иймд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “... үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, ... өмчлөх ... эрхтэй. ...” гэснийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Үндсэн хуулийн цэцийн шийдвэр буцаж үйлчлэх хүрээг тодорхойлсон учир энэхүү дүгнэлт нь гарсан цагаасаа хойш (ex nunc) үйлчлэх бөгөөд буцаж үйлчлэхгүй үр дагавартай болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр

зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад “... үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, ... өмчлөх ... эрхтэй. ...” гэснийг тус тус зөрчсөн байна.

2.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг тус тус зөрчөөгүй байна.

3.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2025 оны 6 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

ГИШҮҮД

Г.БАЯСГАЛАН

О.МӨНХСАЙХАН

Э.ЭНХТУЯА

Ц.ЦОЛМОН

Б.БОЛДБААТАР

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn
Утас: 262420
Хэвлэлийн хуудас: 5
Индекс: 200003